



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2020 оны 08 сарын 26 өдөр

Дугаар 7

Номгон

Г

“Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, энэ  
төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх”  
аймгийн дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх” аймгийн дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрт тусгагдсан зорилт, ажлуудыг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг гарган аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд тусган, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг төсөвт тусган батлуулж, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулан, үр дүнг тооцуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Мөнхсайхан/-д даалгасугай.

3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, иргэдийг идэвхтэй оролцож дэмжин ажиллахыг уриалсугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Байгальмаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Б.БАТБАЯР

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2020 оны 08 дугаар сарын 26-ны  
өдрийн 71 дүгээр тогтоолын хавсралт

**“ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ,  
ЭНЭ ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН  
СЭРГИЙЛЭХ” АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР**

Монгол Улсын Үндсэн хууль, Гэр бүлийн тухай хуулинд тус тус “Гэр бүл, эх, нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална” хэмээн тусгажээ.

Монгол Улсын төрөөс баримтлах хүн амын бодлогод гэр бүлийн амьдралын төвшинг тасралтгүй дээшлүүлж, гэр бүлийн харилцаа, ёс зүйн эрүүл орчин, түүний нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх замаар монгол хүний хөгжлийг дэмжихийг гол зорилгоо болгож, “Гэр бүл нь хүний амьдралын анхдагч орчин, нийгмийн үндсэн нэгж гэж үзэж, түүний хөгжлийн тухай асуудлыг төрийн бодлогын анхааралд байлгана” гэж заасан нь өнөөгийн төр засгаас гэр бүлийн талаар баримтлах бодлого, үзүүлэх үйлчилгээний үндэс болж байна.

Мөн Гэр бүлийн тухай хууль, Жендерэйн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль зэрэг нь гэр бүл дэх эрх тэгш байдал, хүүхэд хамгаалал, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, гишүүдийн үүрэг оролцоог тодорхойлж, төрийн зүгээс үзүүлэх үйлчилгээг нарийвчлан тодорхойлсон.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль хэрэгжиж эхлээд өдгөө 3 жилийн хугацаа өнгөрч байгаа хэдий ч гэр бүлийн хүчирхийллийн тоо төдийлөн буурахгүй, гэр бүлийн харилцаанд энгийн маргаан даамжирсаар хүчирхийллийн хэлбэрт шилжиж, нийгмийн бүхий л давхрагын дунд, ил болон далд хэлбэрээр оршин тогтоосоор байна.

Иймд нийгмийн анхан шатны нэгж болох гэр бүл, хүүхдүүдийн өсөж торних орчинг эрүүл, амар тайван байлгах асуудал зайлшгүй тулгарч байна.

Нэг. Аймгийн хүн ам, гэр бүлийн хүчирхийллийн  
талаарх нөхцөл байдал

Баянхонгор аймаг нь 116.0 мян км.кв нутаг дэвсгэртэй, 20 сум, 105 багтай 88359 хүн амтай, үүнээс 0-17 насны хүүхэд 31991 буюу 36.2%-ийг, 15-34 насны залуучууд 30054 буюу 34%-ийг эзэлж байна.

Аймгийн хэмжээнд 26600 өрх байгаагаас 36.3% нь аймгийн төв буюу Баянхонгор сумд 63.7% нь хөдөө сум орон нутагт амьдарч байна.

Сүүлийн 3 жилийн судалгаагаар аймгийн өрхийн тоо жил ирэх тусам өсөх хандлагатай, хүйсийн хувьд аймгийн нийт хүн амын 49.2 хувийг эрэгтэйчүүд, 50.7 хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаагаас харахад хүйсийн харьцаа харьцангуй ижил түвшинд байгаа нь харагдаж байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр Цагдаагийн газарт 153 үүнээс 27 алба хаагч, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газарт 17 үүнээс 9 мэргэжилтэн, Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн Баянхонгор аймаг дахь салбар нэг цэгийн үйлчилгээний төвд 5, үүнээс 3, хамтарсан багт 86 ажилтан, алба хаагч ажиллаж байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль шинээр батлагдан мөрдөгдөж эхэлснээс хойш гэр бүлийн хүчирхийллийн улмаас Баянхонгор аймагт сүүлийн 3 жилд /2017 онд 34, 2018 онд 31, 2019 онд 17/ нийт 82 гэмт хэрэг бүртгэгдсэний 70 хувь нь согтуугаар, 87.5 хувь нь ахуйн хүрээнд үйлдэгдсэн байна.

Мөн сүүлийн 3 жилд /2017 онд 73, 2018 онд 177, 2019 онд 134/ нийт 384 зөрчил бүртгэгдсэнээс 328 буюу 85.4 хувьд нь баривчлах шийтгэл ногдуулж, хүчирхийлэл үйлдэгчийг зан үйлд нөлөөлөх албадан сургалтанд хамруулжээ.

Дээрх хугацаанд гэр бүлийн хүчирхийллийг удаа дараа үйлдэж баривчлагдсан үндэслэлээр 3 иргэнд эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж, шүүхээс хорих ял ногдуулж шийдвэрлэсэн ба Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн харьяа Баянхонгор аймаг дахь салбар Нэг цэгийн үйлчилгээний төвд хүчирхийллийн хохирогч насанд хүрээгүй 144 хүүхэд, 84 эмэгтэй нийт 228 иргэнийг хамгаалалтанд авч амь нас, эрүүл мэндийг нь хамгаалж, шаардлагатай тусlamж үйлчилгээ үзүүлжээ.

Баянхонгор сумын хэмжээнд сүүлийн 3 жилийн хугацаанд гэр бүлийн зөрчилдөөнт харилцаатай 91, хүчирхийлэлтэй харилцаатай 40 гэр бүлд хамтарсан багийн зүгээс кейс нээн ажиллаж, шаардлагатай тусlamж үйлчилгээ үзүүлсэн 73 тохиолдлыг шийдвэрлэн хааж, удаан хугацаанд үргэлжилж буй 16 тохиолдолтой ажиллаж байна.

Баянхонгор аймгийн гэр бүл салалт сүүлийн 3 жилийн байдлаар /2016-57, 2017-58, 2018-83/ өсөх хандлагатай байна.

Гэр бүл салалтын сөрөг нөлөө хүүхдүүдэд ихээр нөлөөлж, сэтгэл зүйн хямралаас сөрөг зан үйл бий болж, гэмт хэрэг, зөрчлийн холбогдогч, хохирогч болох явдал цөөнгүй байна.

Цаашлаад гэр бүл салалтаас үүдэлтэйгээр эцэг эхийн хараа хяналт суларснаас хойд эцэг, ураг төрлийн холбоотой хамаатан садны хэн нэгний бэлгийн хүчирхийллийн хохирогч болох тохиолдол байсаар байна.

Судалгаанаас харахад гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн тоо сүүлийн 3 жилийн хугацаанд буурч байгаа нь хүчирхийлэл үйлдэгчид баривчлах шийтгэл хүлээлгээд тухайн гэр бүлийн асуудал шийдвэрлэгддэггүй, хүчирхийлэл үйлдэгч эргээд гэртээ очдог, баривчилгааны болон эрүүлжүүлэхийн төлбөрөөс үүдэлтэй санхүүгийн хүндрэл үүсдэг, албадан сургалт чанар үр дүнгүй хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөхгүй байгаагаас гэр бүлийн хүчирхийлэл нуугдмал байдалд шилжих магадлал ажиглагдаж байна.

Хохирогчид өөрийн болон гэр бүлийн нэр хүнд, хүчирхийлэл үйлдэгчийн заналхийлэл зэргээс айх, хүүхдээ бодох, санхүүгийн хараат байдал, хүчирхийлэлтэй эвлэрэх, хүчирхийллийн хохирогч болж байгаагаа ухаarahгүй байх, хувь тавилантайгаа эвлэрэх зэрэг байдлаас цагдаагийн байгууллагад хандахгүй байх тохиолдол мөн элбэг байна.

Монгол Улсын Үндэсний Статистикийн хорооноос 2017 онд гаргасан "Хүчирхийллийн нүцгэн үнэн" сэдэвт судалгаанаас харахад Баянхонгор аймгийн эмэгтэйчүүд хүчирхийллийг тэсвэрлэх, хүлээн зөвшөөрөх хандлага улсын дунджаас өндөр байгаа нь далд хэлбэрийн хүчирхийллийг бий болгох шалтгаан болж стокольмын синдромтой /дасан зохицох хам шинж/ эмэгтэйчүүд олон байгааг үгүйсгэх аргаггүй юм.

#### Хоёр. Хөтөлбөр боловсруулах хэрэгцээ шаардлага

Монгол Улсын иргэн бүр эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах, төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихөөс урьдчилан сэргийлэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг төр иргэнийхээ өмнө хариуцдаг.

Бидний ирээдүй болсон хүүхдүүдийн өсөж, торних, төлөвшиж хүмүүжих анхдагч орчин болох гэр бүлийн орчинг аюулгүй, аз жаргалтай, амар тайван байлгах зайлшгүй шаардлага тулгараад байна.

Иймд Баянхонгор аймгийн өрх гэр бүлийн харилцаа болон хүчирхийллийн өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлыг судалж, хэрэгцээ шаардлагыг тодорхойлон, хүчирхийлэлтэй гэр бүлд чиглэсэн оновчтой төрийн үйлчилгээг үзүүлэх нь зүйтэй юм.

Баянхонгор аймгийн хэмжээнд сүүлийн 3 жилд гэр бүлийн хүчирхийллийн улмаас 82 гэмт хэрэг, 384 зөрчил бүртгэгдэж гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчил, шүүхийн шийтгэврээр баривчлагдсан иргэдийн тоо буурсан боловч, хүчирхийлэл таслан зогсоогдохгүй байгаа нь гэр бүлийн харилцаанд тулгамдаж буй аливаа асуудлыг шийдвэрлэх, тэдний гэр бүлийнхээ өмнө хүлээх үүрэг, эцэг, эх байх хариуцлагыг нэмэгдүүлэх, хүүхэд хүмүүжлийн зерэг аргад суралцуулах, асуудлыг хүчирхийллийн бус аргаар шийдвэрлэхэд зөвлөн туслах шаардлага тулгарч байна.

Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, шуурхай таслан зогсоох, урьдчилан сэргийлэхэд салбар хоорондын уялдаа холбоо, мэргэжлийн байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх байдлаар хүчирхийллийн хохирогчдын аюулгүй байдлыг хамгаалах, нөхөн сэргээх, шаардлагатай тусlamж үйлчилгээ үзүүлэх, хүчирхийлэгчийн үйлдлийг таслан зогсоох, хариуцлага хүлээлгэж, тэдний зан үйлд нөлөөлөх байдлаар хамtran ажиллах нь чухал байна.

Мөн гэр бүлийн хүчирхийллийн давхар болон дам хохирогч болох хүүхдийг гэмт хэрэг, зөрчилд холбогдох, өртөж хохирохос урьдчилан сэргийлэхэд эцэг эхийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ шаардлагатай насанд хүрээгүй хүүхдэд хэрэгцээт тусlamж үйлчилгээ үзүүлэх асуудлыг хүүхдийн өмнө үүрэг хүлээсэн мэргэжлийн байгууллага, албан тушаалтууд хамtran хэрэгжүүлэх.

Хууль зөрчсөн, гэмт хэрэг, зөрчилд холбогдож болзошгүй, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдийн гэр бүлийн байдлыг судлахад ихэвчлэн хүчирхийлэлтэй болон эцэг эх нь салсан тусдаа амьдардаг, хойд эцэгтэй гэх мэт гэр бүлийн харилцаанд ямар нэгэн зөрчилтэй орчинд амьдарч байгаагаас хараад гэр бүлийн орчин, эцэг эхийн хоорондын харилцаа хүүхдийн хүмүүжилд чухал нөлөө үзүүлж буйг илтгэж байна.

Хүүхэд гэмт хэрэгт холбогдох, гэмт хэргийн улмаас хохирч байгаа нь эцэг эхийн хараа хяналт, анхаарал халамж сул, өрх толгойлон суралцуулдаг, тэдэнтэй ярилцдаггүй, тулгамдаж буй асуудлыг нь сонсож, шийдвэрлэдэггүй зэрэг томчуудын буруутай үйл ажиллагаа маш ихээр нөлөөлж байна.


Мөн залуу гэр бүлд чиглэсэн тодорхой бодлого боловсруулан ажиллах шаардлага харагдаж байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх энэ төрлийн гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 1000 гаруй иргэдээс санал асуулга авахад дараах байдлаар хариулжээ.

**Таны амьдарч буй сум баг,  
хороонд гэр бүлийн  
хүчирхийлэл байдаг уу?**




**Та гэр бүлийн хүчирхийллийн  
талаар хэр мэдлэгтэй вэ?**




**Та хэн нэгэн / хөрш айл, хамаатан садан /  
хүчирхийлэлд өртөж байгаа талаар  
дуудлага мэдээлэл цагдаагийн  
байгууллагад өгч байсан уу?**



**Та гэр бүлийн хүчирхийллийн  
хэлбрүүдийг мэдэх үү?**



**Гэр бүлийн харилцаанд маргаан үүсгэж, улмаар хүчирхийлэл бий  
болгож буй хүчин зүйл юу вэ? /1-3 хариулт дугуйлж болно/**



Үүнээс дүгнэхэд гэр бүлийн хүчирхийлэл бий болгож байгаа хүчин зүйлийн том шалтгаан нь архинаас болдог, иргэдийн амьдарч байгаа орчимд гэр бүлийн хүчирхийлэл тодорхой хэмжээгээр үйлдэгддэг боловч ямар нэгэн байдлаар эрх бүхий байгууллагад мэдээлдэггүй байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, аймгийн Засаг даргатай 2020 онд хамтран ажиллах гэрээнд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг ханган, орон нутгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон төсөвт гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэхээр тусгагдсан нь хөтөлбөр боловсруулах хэрэгцээ шаардлагын давуу тал болсон.

Гурав. Хөтөлбөрийн зорилго, баримтлах зарчим, хугацаа

### 3.1 Хөтөлбөрийн зорилго

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд салбар хоорондын уялдаа холбоог хангах, хүчирхийллийн хохирогчдод цогц үйлчилгээ үзүүлэх, хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх үйл ажиллагааг хуулиар үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтууд хамтран хэрэгжүүлэх, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийг бууруулахад хөтөлбөрийн зорилго оршино.

### 3.2. Хөтөлбөр хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

Хөтөлбөрийг дор дурдсан үндсэн зарчим дээр тулгуурлан хэрэгжүүлнэ.

3.2.1. Орон нутгийн онцлог хэрэгцээ шаардлагад нийцсэн хөгжлийн болон салбарын урт хугацааны бодлогыг дэмжих, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичгүүдтэй уялдах;

3.2.2. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчид үзүүлэх үйлчилгээ, хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах,

3.2.3. Гэр бүлийн хүчирхийлэл, гэр бүл цуцлалтын шалтгаан, түүнд нөлөөлөх хүчин зүйл, гэр бүлийн харилцаанд үүсэх сөрөг үр дагаврын талаарх бодитой судалгааг гаргаж, шалтгаан нөхцөлийг тогтоох,

3.2.4.Өсвөр үе залуучуудад чиглэсэн гэр бүлийн харилцаа, эхнэр нөхрийн үүрэг хариуцлагын талаар амьдрах ухааны модуль сургалтыг шинээр гэр бүл болж буй залуучуудад зохион байгуулж, тогтмолжуулна.

3.2.5. Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчил гэр бүл цуцлалт, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэд, аж ахуй нэгж байгууллага, төрийн бус байгууллагын санал, санаачилгыг дэмжих;

### 3.3 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

Аймгийн “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх” хөтөлбөрийг 2020-2023 онуудад үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Дөрөв. Хөтөлбөрийн зорилт, үр дүн, үйл ажиллагаа

Зорилт 1. Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийг бууруулах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг эрчимжүүлэн, урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулж, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг зөрчлийг тодорхой хувиар бууруулсан байна.

Үр дүн 1.1. Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчил тодорхой хувиар буурч, Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдын амар тайван амьдрах орчин бүрдэж, урьдчилан сэргийлэх ажилд үр дүн гарна.

Зорилт 1-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

1.1.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль шинээр мөрдөгдөж эхэлснээс хойш бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн судалгааг гаргаж, шалтгаан нөхцөлийг тогтоож “Гэр бүлийн хүчирхийлэлгүй сум, баг” болзолт уралдааныг зохион байгуулж, дүгнэх;

1.2.Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын чанар үр дүнг нэмэгдүүлэх, сургалтыг ТББ-аар гэрээлэн гүйцэтгүүлэх;

1.3.Иргэдийн гэр бүлийн хүчирхийллийн талаарх ойлголт, нөлөөлөл хандлагыг нэмэгдүүлэх, хүчирхийллийн хэлбэрүүд болон хууль эрх зүйн актуудыг сурталчлан таниулах, гарын авлага, тараах материал, видео шторк зэргийг өвөрмөц байдлаар бэлтгэн иргэдэд хүргэх, хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглан олон нийтэд мэдээлэх,

1.4.Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх чиглэлээр хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагууд, иргэдийг сайн дурын үндсэн дээр татан оролцуулах, хамтран ажиллах,

1.5.Орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн загвар болгоор аймгийн хэрэгжүүлж буй “Шар карттай өрх” -ийн үйл ажиллагааг дэмжих,

1.6.Хамтарсан багийн гишүүдтэй хамтран хүчирхийлэлд өртөж буй зорилтот бүлгийг тодорхойлон “Гэрийн эргэлт” зохион байгуулж, соён гэгээрүүлэх ажил, арга хэмжээ зохион байгуулах,

1.7.Иргэдийн гэр бүлийн хүчирхийллийн талаар мэдээлэх хуулиар хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх чиглэлээр төлбөртэй мэдээлэл авах журмыг хэрэгжүүлэх, сурталчлах

1.8.Гэр бүлийн хүчирхийлэл удаа дараа үйлддэг иргэдийг хамтарсан багийн саналыг үндэслэн архины албадан эмчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах,

Зорилт 2. Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг зөрчлийг шалган шийдвэрлэж буй эрх бүхий албан тушаалтнуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, Хохирогчдын нууцлал болон аюулгүй байдлын хангаж ажиллах, энэ төрлийн гэмт хэрэг зөрчлийг шалгаж шийдвэрлэх чиглэлээр мэргэшүүлэх сургалтанд үе шаттайгаар хамруулах

Үр дүн 2.1. Хэрэг хянан шийдвэрлэх болон зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий алба хаагчдын мэргэжлийн ур чадвар нэмэгдэнэ.

Хохирогчдын аюулгүй байдлыг хангах тогтолцоо бий болж, орон нутгийн хэмжээнд жишиг бий болно.

Зорилт 2-ын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

2.1.Хэрэг хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий алба хаагчид, Прокурор, шүүхийн эрх бүхий албан тушаалтнуудыг мэргэшүүлэх сургалтанд үе шаттайгаар хамруулах

2.2.Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчил шалган шийдвэрлэх, хяналт тавих, эцэслэн шийдвэрлэж буй эрх бүхий албан тушаалтнуудын ойлголт хандлагыг нэгтгэх чиглэлээр сургалт, зөвлөгөөнийг тогтмол зохион байгуулах, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, хохирогчийн аюулгүй байдлыг хангах асуудлыг шүүхийн шийдвэрт тусгуулан хэрэгжүүлэх

2.3.Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангуулан ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчдын техник хэрэгсэл /гэр бүлийн хүчирхийллийн мэдээллийн сан буюу EGBV программ бүхий таблет/, тусгай хэрэгсэл /энгэрийн камер, зургийн аппарат, дуу хураагуур, өнгөт принтер/ зэргийг албан хэрэгцээнд нь олгож, ашиглуулах,

2.4.Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч болон хохирогчийн талаарх мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, статистик мэдээллийг боловсронгуй болгох, үйл ажиллагаандаа ашиглах, салбар хооронд мэдээлэл солилцох,

2.5.Гадаад орны туршлага судалж нэвтрүүлэх, шинэ санал санаачилгыг дэмжиж ажиллах,

Зорилт 3. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн хохирогч болон холбогдогч нарт шаардлагатай тусlamж үйлчилгээ үзүүлэх, сэтгэл зүйн болон хууль эрх зүйн зөвлөгөө тусlamж үзүүлэх таатай орчин бүрдүүлэх

Үр дүн 3.1. Хүчирхийлэл үйлдэгчид ганцаарчилсан зөвлөгөө өгөх, зан үйлд нь нөлөөлөх сургалт, уулзалтыг зохион байгуулах, хүчирхийллийн хохирогч

эмэгтэй болон насанд хүрээгүй хохирогчтой уулзах, зөвлөгөө өгөх шаардлагатай орчин бий болсон байна.

Зорилт 3-ын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.1. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч болон насанд хүрээгүй хүүхдүүдтэй уулзах, тайвшуулах, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, мэдүүлэг авах өрөөг тусгайлан тохижуулах тооцоо судалгаа гарган тохижуулж, үйл ажиллагаандаа ашиглах

Зорилт 4. Өсвөр үе, залуучуудад гэр бүлийн боловсрол олгох, гэр бүлийн амьдралд бэлтгэх, гэр бүлийнхээ өмнө хүлээх үүрэг хариуцлага, чадварыг эзэмшүүлэх

Үр дүн 4.1. Эцэг, эх байх үүрэг хариуцлагаа ухамсарлаж, хүүхдийг үл хайхрах байдал, эцэг, эх байх үүргээ биелүүлэх ухамсар нэмэгдэж, маргааныг хүчирхийллийн бус аргаар шийдвэрлэх чадвар эзэмшинэ.

Гэр бүлийн хүчирхийллийг гэмт хэрэг, зөрчил буурч, гэр бүл цуцлалтын тоо багасна.

Зорилт 4-ын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.1.Хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүчирхийллийг бууруулах, таслан зогсоох чиглэлээр эцэг, эхчүүдэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг тогтмолжуулах,

4.2.Хүүхдийг гэр бүлийн орчинд эсэн мэнд, аюулгүй, хүчирхийллээс ангид өсгөх, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, гэрлэх ёслолын ордонтой хамтран ажиллах, залуу гэр бүлийг дэмжих, амьдрах ухааны модуль сургалтыг зохион байгуулж, хэвшүүлэх;

4.3.Эцэг, эх байх үүргээ биелүүлэхгүй, хүүхдээ асран хамгаалах үүрэгтээ хайнга хандаж буй эцэг эхчүүдэд холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх, үүрэг хариуцлагыг ухамсарлуулах, салбар хоорондын уялдааг хангах

4.4.Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн хохирогч, холбогдогч нарт сэтгэл зүйн үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлэх,

4.5.Хүчирхийллийн улмаас гэр бүлээ цуцлуулсан хохирогчийн аюулгүй байдлыг хангах, хүчирхийлэл үйлдэгчид хуульд заасан хязгаарлалт хэрэглэх,

4.6.Гэр бүл салалтаас үүдэлтэйгээр хохирч буй хүүхдүүдийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр мэргэжлийн байгууллагууд хамтран ажиллах, хойд эцэг, эхтэй болон айлд амьдардаг хүүхдүүдийн судалгааг гаргаж, тэдэнд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах;

Зорилт 5 Иргэдэд хууль зүйн мэдлэг, эрх зүйн боловсролыг нээлттэй, хүртээмжтэй хэлбэрээр эзэмшигүүлэх замаар өдөр тутмын амьдралдаа хэрэглэх чадварыг нэмэгдүүлэх;

Үр дүн 5.1. Эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлыг зөв оновчтой зохион байгуулсанаар иргэдийн хууль, эрх зүйн анхан шатны мэдлэгийн төвшин дээшилж, хууль тогтоомжийг амьдралдаа хэрэглэх, эрх ашгаа хамгаалах чадвартай болсон байна.

Зорилт 5-ын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

5.1. Гэр бүлийн хүчирхийллийн талаарх иргэдийн ойлголт хандлагыг нэмэгдүүлэх чиглэлээр зорилтот бүлэгт /малчин эмэгтэйчүүд, төрийн алба хаагч, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд/ чиглэсэн сургалт зохион байгуулах,

5.2. Гэр бүлийн хүчирхийллийн хор уршгийг сурталчилсан тэмцээн уралдаан зохион байгуулж, олон нийтэд сурталчилах,

5.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоотой хамтран хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, тэдэнтэй харилцах анхан шатны хэлмэрч бэлтгэх сургалтыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах,

#### Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга замууд

5.1. Хөтөлбөрийг аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг хөтөлбөрийн хэрэгжилтийг хариуцан орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэхэд удирдлага арга зүйгээр хангаж ажиллана.

5.2. Хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг аймгийн Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлэн баталгаажуулж бүх сумдад хүргүүлнэ.

5.3. Хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа бүрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт бүрийг төлөвлөн хэрэгжүүлж, хэрэгжилтийг ханган ажиллах чиглэлээр аймгийн Засаг даргын захирамжаар үүрэгжүүлж, хяналт тавих ажлыг Хууль, эрх зүйн хэлтсийн даргад үүрэг болгоно.

5.4. Хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүр аймгийн Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлсний дараа иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд оруулж, үнэлүүлнэ.

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалт

6.1. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь Монгол Улсын хууль тогтоомж, эрх зүйн акт болон бусад баримт бичгийн дагуу зохион байгуулагдана.

6.2. Хөтөлбөрийг зохион байгуулах аймгийн зөвлөлийг аймгийн Засаг дарга ахлах бөгөөд орлогч дарга нь Засаг даргын орлогч, бүрэлдэхүүнд нь аймгийн

Засаг даргын Тамгын газрын хэлтэс, агентлагийн дарга нар, сумдын Засаг дарга нар, орон нутгийн хэвлэл мэдээллийн ажилтнууд орно.

6.3. Хөтөлбөрийг аймгийн хэмжээнд зохицуулах, мэргэжлийн арга зүйгээр удирдах үүргийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс хэрэгжүүлнэ.

6.4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд аймгийн бүх сумдад салбар зөвлөл ажиллах бөгөөд түүнийг сумдын Засаг дарга нар ахалж, орон нутгийн төрийн захиргааны болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөлөл орсон байна.

6.5. Дэд хөтөлбөрийн холбогдох заалтуудыг аймгийн Засаг даргын хэлтэс агентлагийн дарга нар болон сумдын Засаг дарга нартай байгуулах үр дүнгийн гэрээнд тусгуулан хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

Долоо. Хэрэгжилтийн үнэлгээний арга хэлбэр, үе шат

7.1. “Гэр бүлийн хүчирхийллийн” хөтөлбөрт тусгагдсан зорилтын хүрээнд дэх үйл ажиллагааг жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөө гарган хэрэгжүүлнэ.

Нэгдүгээр үе шат буюу 2020-2021 он /2021 оны 3 дугаар сард үнэлгээ хийх/

Хоёрдугаар үе шат буюу 2021-2022 он /2022 оны 3 дугаар сард үнэлгээ хийх/

Гуравдугаар үе шат буюу 2022-2023 он /2023 оны 03 дугаар сард үнэлгээ хийх/

7.2. Явцын үнэлгээ буюу мониторингийг нэг жил тутамд зохион байгуулж, эцсийн үнэлгээг 2023 онд зохион байгуулж, дунг мэдээлж ажиллана.

7.3. Төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг аймгийн ажлын хэсэг Засаг дарга, Хууль, эрх зүйн хэлтсийн даргад мэдээлж, тайлагнах ба Хууль эрх зүйн хэлтсийн тухайн асуудлыг хариуцсан мэргэжилтэн, Цагдаагийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн Баянхонгор аймаг дахь салбар Нэг цэгийн үйлчилгээний төв иргэдэд мэдээлэх ажлыг хариуцан зохион байгуулна.

7.4. Биелэлтийн явц, үр дүн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг Хууль, эрх зүйн хэлтсийн дарга холбогдох байгууллагад уламжилж шийдвэрлүүлж ажиллана.

Найм. Хөтөлбөрийн санхүүжилт

8.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ.

8.1.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өөрийн хөрөнгө

8.1.2. Орон нутгийн төсвийн хөрөнгө

8.1.3.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зориулалтаар улсын төсвөөс орон нутагт тусгагдсан хөрөнгө, тоног төхөөрөмжийн дэмжлэг

8.1.4. Бусад эх үүсвэр

8.2.Хөтөлбөр хэрэгжүүлэхэд төрөөс үзүүлэх дэмжлэгийг иргэн, аж ахуйн нэгжийн өөрийнх нь хөрөнгө оруулалттай хослуулан хөтөлбөрт заасан үр дүнд хүрэх хариуцлагын тогтолцоог бүрдүүлнэ.

Ес . Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

9.1 Дэд хөтөлбөрийн үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр хэмжинэ .

9.1.1.Хөтөлбөрт тусгагдсан гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөө,

9.1.2. Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн тоо баримт өссөн, буурсан үзүүлэлт,

9.1.3. Гэр бүлийн хүчирхийллийн талаарх иргэдийн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж буй байдал,

9.1.4. Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд гарч буй ахиц, гэмт хэрэг, зөрчлийг давтан үйлдэж буй байдал, гэмт хэргийн нөхцөл байдал,

9.1.5. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч болон хохирогчийн талаарх мэдээллийн сан бүрдүүлсэн байдал, статистик мэдээллийг боловсронгуй болгосон эсэх,

9.1.6. Үл хайхрагдсан болон хараа хяналтгүй, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн тоо буурсан байдал, Эцэг, эхчүүд хүүхэддээ тавих анхаарал халамж сайжирсан эсэх,

9.1.10.Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийг шалгаж, шийдвэрлэж буй эрх бүхий албан тушаалтнуудын ур чадвар нэмэгдсэн байдал, хэргийн шийдвэрлэлт, хохирогчын аюулгүй байдлын хамгаалалт,

9.1.11. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг дагаж гарсан журмуудын хэрэгжилт хангагдаж буй байдал,

9.1.12. Зорилтот иргэдэд чиглэсэн үйлчилгээ үр дүнд хүрсэн эсэх,

9.1.13. Иргэдийн хууль, эрх зүйн мэдлэг дээшилсэн байх,

9.1.14. Аймгийн хэмжээний гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчил буурсан байх зэргийг харгалзана.